



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/МНС-

Арвайхээр

### Тендерийн гүйцэтгэгчийг сонгох, тендер хүчингүй болгон дахин зарлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 30 дугаар зүйлийн 30.1.1, 32 дугаар зүйлийн 32.1.1, заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2019 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 72 дугаар зөвлөмжийн дагуу улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих Засаг даргын Тамгын газрын барилгын их засвар, тоног төхөөрөмж /Өвөрхангай Зүүнбаян-Улаан, Бат-Өлзий, Хужирт сум/ ЗГХЭГ/201902048 ажлын гүйцэтгэгч болон нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн багц-1 Зүүнбаян-Улаан сумын Засаг даргын Тамгын газрын их засвар багцыг 58050886 (тавин найман сая тавин мянга найман зуун наян зургаа) төгрөгөөр Луужинконсалтинг ХХК-иар, багц-2 Хужирт сумын Засаг даргын Тамгын газрын их засвар багцыг 39930000 (гучин есөн сая есөн зуун гучин мянга) төгрөгөөр Гүнчимэгтэй ХХК-иар, багц-3 Бат-Өлзий сумын Засаг даргын Тамгын газрын их засвар багцыг 198720418 (нэг зуун ерэн найман сая долоон зуун хорин мянга дөрвөн зуун арван найм) төгрөгөөр Халгих трейд ХХК-иар тус тус гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т даалгасугай.

3. Гүйцэтгэгч аж ахуйн нэгж санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн өгөхийг Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-т үүрэг болгосугай.

4. Нэг ч оролцогч үнийн санал ирүүлээгүй багц-4 Сумдын Засаг даргын Тамгын газрын тавилга, тоног төхөөрөмж багцыг хүчингүй болгосугай.

5. Дээрх хүчингүй болсон багцыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 1.1 дэх заалтын дагуу хязгаарлагдамал тендер шалгаруулалтаар цахимаар дахин зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100752